



**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

Салбар ажлын хэсэг байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны А/348 дугаар тушаал, Налайхын үйлдвэрлэл, технологийн парк хаалттай хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын захиргаа, хүний нөөц, гадаад, дотоод хамтын ажиллагаа, олон нийттэй харилцах, санхүү, хөрөнгө оруулалт, хууль тогтоомж, эрх зүй, хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиг үүрэгт дүн шинжилгээ хийх Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны А/348 дугаар тушаалаар байгуулсан дэд ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий салбар ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Н.Пүрэвсүрэн (Ахлах мэргэжилтэн)

Гишүүд:

О.Чулуун-Эрдэнэ (Гадаад харилцаа хамтын ажиллагаа
хариуцсан мэргэжилтэн)

Д.Номин-Эрдэнэ (Захиргааны мэргэжилтэн)

Х.Бямбаа (Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн)

Нарийн бичиг:

Б.Болортуяа (Хуулийн мэргэжилтэн)

2. Чиг үүргийн шинжилгээ хийхтэй холбоотой судалгаа, мэдээллийг 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Н.Пүрэвсүрэн)-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ч.РАДНААБАЗАР

D:\2025 он\04 Даргын А тушаал\А тушаал.doc

1225030109